



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/27

Номгон

Баянхонгор сумын 5, 6 дугаар сургуулийн  
үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэлийг хангах  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн “Баянхонгор сумын 5 дугаар сургуулийн барилгын ажлыг эрчимжүүлэх тухай” 2020 оны 13, “Хуулийн этгээд байгуулах тухай” 2021 оны 55, “Нэр өөрчлөх тухай” 2021 оны 73 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянхонгор сумын сумын “Есөнбулаг” 9 дүгээр багийн нутаг дэвсгэр дэх 5 дугаар сургууль, Баянхонгор сумын шинэ суурьшлын бүсийн “Гэгээн сумади” сургууль цэцэрлэгийн цогцолборын сургалт, үйл ажиллагааг 2021-2022 оны хичээлийн жилийн хоёрдугаар улирлаас эхлүүлэх бэлтгэлийг хангах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Энхбаяр /Байгаль орчин, уул уурхай, нийгмийн салбар хариуцсан орлогч

Гишүүдэд Т.Ганболд -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн

Г.Батбаяр -Боловсрол, шинжлэх ухааны газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга

С.Гандалай -Боловсрол, шинжлэх ухааны газрын Сургалт арга зүйн хэлтсийн дарга

Л.Оюунбилэг -Боловсрол, шинжлэх ухааны газрын Статистик хариуцсан мэргэжилтэн

Ж.Мөнхсоёл - Баянхонгор сумын Засаг дарга

Э.Батцэцэг -Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

691220061

2.

О.Дашдаваа -Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын Боловсрол, соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Ц.Энхтөр -Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Ажлын хэсгийг шуурхай зохион байгуулалт, удирдлага арга зүйгээр ханган тухай бүрд тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Энхбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН